



“ЦЭСДА” ХХК-НИЙ ЗАХИРАЛ
ЦОРХОНТАМИР ТАНД

БАЯНХОНГОР АЙМГИЙН
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР
УЛСЫН БАЙЦААГЧИЙН
ДҮГНЭЛТ

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-20-15

2020-01-11. № 05-03-011/11

танай _____ -ны № _____ -т

Г Зураг төслийн тухай Т

ЦЭСДА ХХК-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу Баянхонгор аймгийн Өлзийт сумын Улаан-уул 6 дугаар багт баригдах 240 хүний суудалтай соёлын төвийн барилгын ажлын зурагт Монгол Улсын Эрүүл ахуй тухай хууль, Мэргэжлийн хяналтын өрөнхий газрын даргын 2017 оны А/164 тоот “Барилга байгууламж барих газрын байршил тогтоох, барилгын зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтад оруулах, өргөтгөх, зориулалтыг өөрчлөхөд эрүүл ахуйн хяналт хийж, дүгнэлт гаргах заавар” холбогдох стандарт, норм дүрэм, журмын хэрэгжилтийг ханглулахаар 2020 оны 01 дүгээр сарын 21-ны өдөр ажлын зурагт эрүүл ахуйн хяналт хийлээ.

Нэг. Барилга байгууламжийн зориулалт:

Баянхонгор аймгийн Өлзийт сумын Улаан-уул 6 дугаар багт баригдах 240 хүний суудалтай соёлын төвийн барилга. Барилгын зургийг “ЦЭСДА” ХХК гүйцэтгэсэн. Шифр: ЦЭ-49-09/18/19,

Баянхонгор аймгийн Өлзийт сумын Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн А/10 дугаар захирамжтай, 500 метр квадрат хэмжээтэй, урлаг, соёлын зориулалтаар олгосон байна.

Уг барилга байгууламж нь ногоон байгууламж, авто машины зам талбайтай. Барилга нь тэнхлэгээрээ 34.8м*29.6м хэмжээтэй, 2 давхар, зоорьгүй барилга байхаар төлөвлөсөн.

Нэгдүгээр давхарт: Үзвэрийн танхим, тайз, бэлтгэлийн өрөө, эрэгтэй, эмэгтэй хувцас солих өрөө, ариун цэврийн өрөө, сургалтын өрөө, багш нарын өрөө, касс, эрхлэгчийн өрөө, ажлын өрөө, харуул хамгаалалт, агуулах, дулааныузель, цахилгаан шитны өрөө, холбооны өрөө, касс байрлахаар төлөвлөсөн байна.

Хоёрдугаар давхарт: Номын сан, музей, ариун цэврийн өрөө байрлахаар төлөвлөсөн байна.

Ус хангамж, бохир ус зайлцуулалтын байдал:

Ус хангамжийн эх үүсвэр нь гүний худгаас ба усан хангамжийн системд эрүүл ахуйн шаардлага хангасан цайрдсан ган яндан төлөвлөсөн байна. Халуун усыг хэрэглээний ус халаагчаар шийдвэрлэхээр тусгасан байна.

Тус барилгын бохир ус нь өөрийн урсгалаар зайлцуулагдаж цооногт хуримтлагдахаар төлөвлөсөн байна.

Дулаан хангамж, агаар сэлгэлтийн байдал:

Дулааны эх үүсвэр нь төвийн шугам байна. Дулааны шугам сүлжээг Залаа цагаан хоршооны техникийн нөхцөлийн дагуу хийж гүйцэтгэнэ. Барилгын халаалтын систем нь доороос түгээлттэй, мухардмал эргэлттэй, хоёр хоолойт систем байхаар төлөвлөсөн байна. Халаах хэрэгсэл нь ширмэн радиатор байна.

Агаар сэлгэлтийн системийг механик болон ердийн агаар сэлгэлтийн системтэй байхаар төлөвлөсөн байна. Ариун цэврийн өрөөнүүдэд ердийн агаар сорох систем, үзвэрийн танхимд агаар оруулах болон сорох механик агаар сэлгэлтийн систем төлөвлөсөн байна.

Инженер геологийн судалгаа:

Баянхонгор аймгийн Өлзийт сумын Улаан-уул 6 дугаар багт баригдах 240 хүний суудалтай соёлын төвийн барилгын инженер геологийн судалгааны ажлыг "Топ Гео Техник" ХХК гүйцэтгэсэн байна.

Хоёр. Барилгын ажлын зураг төсөлд илэрсэн зөрчил, дутагдлууд:

- Хуудас бүрт гарын үсэг зурж баталгаажуулаагүй,

Дүгнэх нь:

Барилга байгууламжийг зураг төслийн дагуу гүйцэтгэхэд эрүүл ахуйн талаас татгалзах зүйлгүй болно.

Санал:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ариун цэврийн өрөөг тусгах, хэсэглэлүүдийг стандартын шаардлагад нийцүүлж хийхээр төлөвлөх, налуу замын бариулыг зурагт тусгах,

Хяналт шалгалтын шийдвэрийн талаар гомдол гаргах эрхийн хүрээнд:

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх /Шалгуулсан байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригч, албан тушаалтан хяналт шалгалтын явцад хууль тогтоомж зөрчигдсөн, гаргасан шийдвэр үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо хяналт шалгалт хийсэн байгууллагын эрх баригчид гаргана/, 14.2 дахь /Гомдлыг хүлээж авсан хяналт шалгалтын байгууллагын эрх баригч түүнийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэх арга хэмжээ авна./

Хэрэв гомдол гаргасан байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригч, албан тушаалтан хяналт шалгалтын байгууллагын шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдоо шүүхэд гаргаж болно/.

Хувийг: Өлзийт сумын Засаг Даргын тамгын газарт

ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ Ц.УРАНГОО



ХҮЛЭЭН АВСАН:
ЦЭСДА ХХК-НИЙ ЗАХИРАЛ  Ц.ОРХОНТАМИР

ТАЙЛБАР.....

.....